

ПРЕМИУМ НЭКСУС ХК



2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Ирээдүйг чиглэсэн мэдэгдлийн талаарх анхааруулга

Премиум Нэксус ХК нь энэхүү тайланд “ирээдүйг чиглэсэн” зарим мэдэгдэл агуулагдсан болно. Тухайлбал, тус тайланд “бид таамаглаж байна, бид тооцоолж байна, бид зорьж байна, бид төлөвлөж байна” гэх мэт үгстэй ойролцоо үг,мөн ирээдүй цагийг илэрхийлэх үгс ашиглагдсан болно.Ирээдүйг чиглэсэн мэдэгдэл нь ирээдүйд болох үйл явдал,нөхцөл байдлын баталгаа биш бөгөөд бидний таамагласан нөхцөл байдал биелэхгүй байх магадлалтай ба тэдгээр таамаглалуудад хэт найдах нь учир дутагдалтайг анхаарна уу.

Компанийн бизнесийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлага нь эрсдэл, тодорхойгүй байдал гэх мэт хүчин зүйлс, мөн үүгээр хязгаарлагдахгүй зүйлсээс хамаарч материаллаг зөрүүтэй байж болно. Тиймээс, эдгээр эрсдэл болон тодорхойгүй байдлыг харгалзан үзэж ирээдүйг чиглэсэн мэдэгдэл, төсөөллийг шууд утгаар нь бодитоор биелнэ хэмээн авч үзэх нь өрөөсгөл юм. Мөн, компанийн зүгээс шинэ мэдээ мэдээлэл болон ирээдүйд гарах ялгаатай үр дүн эсвэл аливаа бусад шаардлагын улмаас энэхүү тайланд тусгагдсан ирээдүйд чиглэсэн таамаглалуудыг шинэчлэх эсвэл засварлах аливаа үүрэггүй болохыг мэдэгдэж байна.

Агуулга


- Компанийн тухай 03
- Хувьцаа эзэмшигчдийн хурал, хувьцаа 07
- CU Конвиниенс дэлгүүрийн бизнес 09
- 2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд 14
- Нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтүүдийн товч танилцуулга 28

Премиум Нэксус ХК-ийн удирдлага



Компанийн тухай

Премиум Нэксус ХК-ийн бизнесийн бүтэц




Компанийн тухай

Хөгжлийн үе шат болон Премиум Нэксус

Премиум Корпорэйшн 2015 онд өөрийн 100%-ийн хөрөнгө оруулалтаар Сэнтрал Экспресс нэршлээр Монголын анхны конвиненс дэлгүүрийг нээж байв. 2017 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг байгуулж, 2018 оны 8-р сард дэлхийн конвиненс дэлгүүрийн жишиг стандартын төлөөлөл болох БНСУ-д 18,500 гаруй дэлгүүрээр зах зээлийг манлайлагч CU брэндийн үүсгэн байгуулагч БНСУ-ын жижиглэн худалдааны тэргүүлэгч Би Жи Эф Ритэйл ХК-иас Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийн 10%-ийг эзэмших стратегийн хөрөнгө оруулалт татаж, хамтдаа CU брэндийг Монголд нэвтрүүлсэн.

2021 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO амжилттай хийж хувьцаат компани болсон ба улмаар 2023 оны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлаар хөгжлийн дараагийн шатандаа гарах шийдвэрийг баталж нэрээ Премиум Нэксус ХК болгон өөрчилжээ. Уг өөрчлөлтийн эхлэл нь шинээр хувьцаа гаргах замаар босоо интеграцийн хөрөнгө оруулалт болох Чингис Шар Айраг ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК болон Стора Централ ХХК нарыг нэгтгэсэн явдал юм.



Компанийн тухай

Премиум Нэксус ЭКОСИСТЕМ ба түүний давуу талууд

Борлуулалт болон ашигт ажиллагааны өсөлт:

Ханган нийлүүлэгчдийн хувьд СУ сүлжээ дэлгүүртэй хамтран борлуулалтын прогнозоо улам оновчлох, эрэлтээ зөв таамаглах, үргүй зардлаа бууруулах боломжтой болсноор хамтын ашигт ажиллагаа нэмэгдэх болно.

Байгал орчин, Нийгэм, Засаглалын өндөр стандарт өргөн цар хүрээ:

СУ сүлжээдэлгүүрийн ханган нийлүүлэгчид, ялангуяа жигдүнд үйлдвэрлэгчид энэхүү эко-системд нэгдснээр, Премиум Нэксусийн олон улсын жишигт нийцсэн БОНЗ-ийн практикийг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

Логистик болон нэгдсэн түгээлтийн үр ашиг:

Монголын дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд бүтээгдэхүүний нийт өртгийн 30 орчим хувийг логистикийн зардал эзэлж байгаа нь дэлхийн дундажаас 2-3 дахин өндөр үзүүлэлт юм. Премиум Нэксус нь логистикийн дэд бүтцийн сайжруулалт хийснээр дээрх үр ашиггүй байдлыг арилгах болно.

Үйлчлүүлэгчидийн сэтгэл ханамж:

СУ сүлжээ дэлгүүр үйлдвэрлэгчидтэйгээ хамтран бүтээгдэхүүн хөгжүүлсэнээр хэрэглэгчдийн хэрэгцээнд бүрэн нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж бүрдэнэ. Ингэсэнээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийг өндөр түвшинд хүргэх, үнэнч хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

Хөрөнгө оруулагчдын нэгдмэл ашиг сонирхол:

СУ сүлжээ дэлгүүрийг түшсэн, түүнтэй хамаарал бүхий бизнесүүдийг нэг дор нэгтгэсэнээр тэдгээр бизнесүүд хамтын хүчээр үлэмж үнэ цэнийг бий болгох боломжтой. Ингэсэнээр хөрөнгө оруулалчид энэхүү синергээс бий болох бүх боломжийг хүртэх нөхцөл бүрдэнэ.

Ажилтнуудын өсөж дэвших боломж, сэтгэл ханамж:

Монголын томоохон хөрөнгө оруулалтын компанийн нэг хэсэг болж ажиллах, групп компани дотроо өсөж хөгжих, Премиум туршлагаас суралцах зэрэг боломжууд ажилтнуудад нээлттэй болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурал, хувьцаа

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хууль болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-өөс баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам болон Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04-р сарын 29-ний өдөр амжилттай зохион байгуулсан бөгөөд тус хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 91.35 хувь нь оролцож Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон 2024 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгаантай танилцаж, 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулан батлав.

Үзүүлэлт	2022	2023	2024
Нийт хувьцааны тоо	817,768,643	1,114,252,034	1,114,252,034
Хувьцаа эзэмшигчийн тоо	9,615	9,300	9,300
ХЭХ ирц	84.94	89.04	91.35



Хувьцаа эзэмшигчдийн хурал, хувьцаа


Хувьцааны ханшийн гүйцэтгэл

Премиум Нэксус ХК (CUMN):

₮207.73

Нээлтийн ханш: 208
Нийт гаргасан хувьцаа: 1,114,252,034
Хаалтын ханш: 207.73

Эргэлтэд гаргасан хувьцаа: 1,114,252,034
52 долоо хоног: 170.31 - 209.52
Зах зээлийн үнэлгээ: 231,463,575,022.82



CU Конвиниенс дэлгүүрийн бизнес

CU Конвиниенс дэлгүүрийн алсын хараа, эрхэм зорилго




Эрхэм зорилго

Дэлхийн стандартын
үйлчилгээгээр хүмүүсийн
өдөр тутмын амьдралыг
хялбаршуулна



Алсын хараа

Үйлчилгээгээрээ дэлхийд
танигдана




Үнэт зүйл, бизнесийн үзэл баримтлал

Бидний эрхэмлэх 4 үнэт зүйлс:

- Амжилт гаргагч
- Өсөх сэтгэлгээтэй
- Үйлчлүүлэгч төвтэй
- Шилдэг хамтрагч

CU Конвиниенс дэлгүүрийн бизнес

Үйл ажиллагааны онцлог, давуу тал



Конвиниенс дэлгүүрүүд нь үйлчлүүлэгчдэд хамгийн ойр, үргэлж нээлттэй байж хэрэглэгчдийн хэрэгцээт бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол нийлүүлдгээрээ онцлогтой. Премиум Нэксус ХК нь CU брэндийн конвиниенс дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд хэрэгцээт бүтээгдэхүүн үйлчилгээг 24 цагийн турш хамгийн тав тухтай, хүртээмжтэй хүргэхээр зорин ажиллаж байна. Бид бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд тасалдалгүй тогтмол хүргэж, тэдний сэтгэл ханамжийг хамгийн өндөр түвшинд байлгахын тулд бүтээгдэхүүн үйлчилгээний ялгарал, логистик, технологийн цогц шийдлийг бий болгон ажиллаж байна.

CU Конвиниенс дэлгүүрийн бизнес

Премиум Нэксус ХК үйл ажиллагааны гол үзүүлэлт

Хамгийн их сүлжээ дэлгүүртэй

2024 оны Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгж #7

Тэргүүлэгч жижиглэн худалдааны компани

Зах зээлийн үнэлгээ : 227 тэрбум төг



Нэгтгэсэн борлуулалт:
362+ тэрбум төг



Дэлгүүрийн тоо:
495



Ажиллагсдын тоо:
5,000+



Өдрийн хэрэглэгчдийн тоо:
200,000+



Хамтран ажиллагчид:
500+



Хувьцаа эзэмшигчид:
9,900+



+495 Дэлгүүрүүд
4,200+ Дэлгүүрийн ажилтнууд



Логистикийн бааз
120+ Логистикийн ажилтнууд



2 Түгээлтийн төв
240+ Агуулахын ажилтнууд



Хоолны үйлдвэр
220+ Үйлдвэрийн ажилтнууд




Төв оффис
240+ Оффисын ажилтнууд

CU Конвениенс дэлгүүрийн бизнес

CU конвениенс дэлгүүрийн үйл ажиллагааны гол үзүүлэлт


Үйлчлүүлэгчдийн тоо (сая)




Дэлгүүрийн тоо

	Өссөн дүн	2025H1
УБ	+16	413
Орон нутаг	+34	82

Ажиллагсдын тоо



Дэлгүүрийн тоо



CU Конвиниенс дэлгүүрийн бизнес

CU харьцуулсан болон нийт дэлгүүрийн гүйцэтгэл

Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл

	2025 оны 1-р хагас
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	16%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	9%
Сагсны үнийн өсөлт	7%

Харьцуулсан дэлгүүрийн тоо: 360

Нийт дэлгүүрийн гүйцэтгэл

	2025 оны 1-р хагас
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	8.4%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	0.4%
Сагсны үнийн өсөлт	8.0%

Нийт дэлгүүрийн тоо: 393 → 495


2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

CU Конвиниенс дэлгүүр

Гол онцлох үйл явдлууд

- 58 шинэ дэлгүүр нээж, 8 дэлгүүр хааснаар нийт 495 дэлгүүртэй болсон.
- Улаанбаатар хотод 413, орон нутагт 82 дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.
- Нийт 15 аймагт хүрээгээ тэлсэн.

Дэлгүүрийн тоо	2024	2025Н1
CU	445	495



CU Конвиниенс дэлгүүр нь Монгол орныг ирэх жуулчид болон нутгийн иргэдэд олон улсын стандартад нийцсэн үйлчилгээ хүргэхээр Улаанбаатараас алслагдмал аймгууд болох Хөвсгөл, Баянхонгор, Дорнод аймгуудад шинээр салбар дэлгүүрээ нээн Монгол орны 15 аймагт хөл тавилаа. CU конвиниенс дэлгүүр нь Монгол орон даяар амжилттай өргөжин тэлснээр бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, шинээр ажлын байрууд бий болгохын зэрэгцээ орон нутгийн иргэд, байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлж, хөгжил дэвшлийг хамтдаа бүтээх боломж бүрдэж байгаа юм.


2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

CU Конвиниенс дэлгүүр



Кимбабны орц найрлага, амт, хэмжээг шинэчлэн илүү олон төрлийг, шинэ өнгө төрхтэйгөөр нэвтрүүллээ.

Японы Нийгата мужийн цагаан будаа ашиглаж эхэлсэн бөгөөд хэрэглэгчдэдээ илүү чанартай, амттай онигириг олон сонголттойгоор хүргэж эхэллээ.




CU-н нэрийн бэйкери брэнд болон DAILY BAKED-г танилцуулж, олон төрлийн тренд бүтээгдэхүүнүүдийг хүргэж байна.



Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн чанарын стандартыг хангасан ISO22000, HACCP нэвтрүүлсэн үйлдвэрт хийсэн амтат бууз, банш болон Хөвсгөр буузыг зах зээлд нэвтрүүллээ.

2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

CU Конвиниенс дэлгүүр



Улаанбаатар марафон болон DJ эвент үйл ажиллагаа

CU Конвиниенс дэлгүүр нь 20 дах жилдээ уламжлал болон зохион байгуулагдаж буй Улаанбаатар марафоны үйл ажиллагаанд зориулан хэрэглэгчдэдээ онцгой урамшууллуудыг хүргэн ажилласан билээ. Түүнчлэн Компанийн илч тамирчнаар Марафон гүйлтийн спортын мастер Орхоны НАЦАГДОРЖ оролцуулан хагас марафон 21км-т 4-р байранд орсон амжилтыг үзүүлсэн юм. Мөн тухайн өдрийг улам онцгой болгон CU Гранд Оффис салбарт DJ эвент зохион байгуулж, үйлчлүүлэгч бүрд мөстэй аяга үнэгүй тараан залуучууд нэг өдрийг сонирхолтой өнгөрүүллээ.



3-р эмнэлгийн ариун цэврийн өрөөний засварыг хийж гүйцэтгэлээ

Нийгмийн хариуцлагын хүрээнд Шастины нэрэмжит 3-р эмнэлгийн ариун цэврийн өрөөг бүрэн шинэчиллээ. Өдөрт 1500 гаруй хүн үйлчлүүлдэг тус эмнэлгийн ариун цэврийн өрөөнд 68 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, орчин үеийн эмнэлгийн шаардлага хангасан тоног төхөөрөмж суурилуулж, өвчтөнүүдийн тав тух, эрүүл ахуйн стандартыг хангасан цэвэр, цэмцгэр орчныг бүрдүүлж, хүлээлгэн өглөө.

2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

CU Конвиниенс дэлгүүр



2025 оны RETAIL ASIA AWARDS-аас “Convenience store of the year - Mongolia” шагнал хүртлээ

Энэхүү нэр хүндтэй шагнал нь Ази-Номхон далайн бүсийн жижиглэн худалдааны салбар дахь шилдэг туршлага, инновацыг үнэлдэг бөгөөд Монголын зах зээлд конвиниенс дэлгүүрийн соёлыг амжилттай нэвтрүүлсэн Премиум Нэксус компанийн үйл ажиллагаа, өсөлт, нийгмийн хариуцлагатай бодлогын үр дүн юм.

- Премиум Нэксус компани 2018 онд CU брэндийг Монголд амжилттай нэвтрүүлж, 480+ салбар, 3,500+ ажилтантай үндэсний хамгийн том жижиглэнгийн сүлжээг бий болгожээ.
- CU нь өдөр бүр 200,000 гаруй хэрэглэгчийг хүлээн авч, 400+ нийтийн ариун цэврийн өрөө, оюутнуудад зориулсан уян хатан ажлын байр зэргээр хэрэглэгчдэд ээлтэй орчныг бүрдүүлсээр байна.
- CU апп, CU Pay зэрэг технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүлж, жижиглэн худалдааны шинэ дижитал үеийг Монголд авч ирсэн нь онцлох жишээ юм.

2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

CU Конвиниенс дэлгүүр

Премиум Нэксус ХК - Монгол улсын ТОП 100 аж ахуйн нэгжийн 7-р байранд шалгарлаа

2024 онд Монгол улс нийт 27.4 их наяд төгрөгийн татварын орлого төвлөрүүлсний 28% буюу 7.64 их наяд төгрөгийг ТОП-100 аж ахуйн нэгж бүрдүүлжээ.

Премиум Нэксус ХК нь Монгол улсын ТОП 100-д 5 дахь удаагаа багтаж, дараах амжилтуудыг үзүүллээ:

- Борлуулалтын орлогоороо 25-р байр
- Төлсөн татварын дүнгээр 65-р байр
- Даатгуулагчийн тоогоор 2-р байр
- Ашгийн хэмжээгээр 42-р байр
- Хөрөнгийн эрэмбээр 51-р байр



2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

CU Конвиниенс дэлгүүр

ICU хүүхэд хамгааллын төсөл ЦЕГ 102
аппликэйшнтэй хамтран үйл ажиллагаагаа
өргөжүүллээ

CU брэнд 2021 оноос эхлэн “CU ЧАМД ТУСАЛЪЯ” уриатай I CU хүүхэд хамгааллын төслийг амжилттай хэрэгжүүлж эцэг эхээсээ төөрсөн 14 хүүхдийг дэлгүүрт аюулгүй байлгаж, эцэг эхэд нь хүлээлгэн өгсөн бөгөөд энэхүү ажиллагаанд цагдаагийн газартай хамтран ажилласаар байна.

Энэ оноос эхлэн хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн ЦЕГ-ийн 102 аппликэйшн-тай холболт хийж, төөрсөн, сураггүй алга болсон хүүхдийн мэдээллийг CU конвиниенс дэлгүүрийн бүх салбарын POS дэлгэцүүдээр олон нийтэд шуурхай хүргэх ажлуудыг зохион байгуулж байна.

ЦЕГ-ийн 102 аппликэйшн болон CU сүлжээ дэлгүүрийн POS системүүдийн интеграци нь төөрсөн хүүхдүүдийн мэдээллийг богино цаг хугацаанд олон нийтэд хүргэх боломжийг бүрдүүлж, хүүхэд хамгааллын ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой хамтрал юм.



2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

CU Конвиниенс дэлгүүр

CU конвиниенс дэлгүүр ахин нэг шинэ жишиг тогтоох салбараа нээлээ

Улаанбаатар хотоос зүүн тийш гарах замд CU конвиниенс дэлгүүрийн шинэ салбар өнөөдөр нээлтээ хийлээ. Хонхорын зам дагуу байрлалтай энэ салбар нь холын аялалд гарах хүмүүст зориулсан томоохон зогсоол, орчин үеийн тоноглол бүхий ариун цэврийн өрөө, 24 цагийн үйлчилгээгээрээ онцлог юм.

“Дэлгүүрүүд ч бас ариун цэврийн өрөөг ингэж хийж болдог юм шүү” гэж хэлээд байгаа мэт, энэ салбар нь орчин үеийн шийдэл, тоноглолтой, нэг удаад 10 хүн зэрэг үйлчлүүлэх боломжтой, багачуудад зориулсан гарын угаалтууртай, цэвэрхэн ариун цэврийн өрөө нь олон хэрэглэгчийн ая тухыг бүрдүүлж, үйлчилгээний салбарт шинэ стандарт тогтоож буйг харуулж байна.

Зам дагуу олон автомашин зогсох зогсоолын бүтээн байгуулалтыг шийдсэн байгаа нь энэ салбарын хоёр дахь чухал онцлог юм. Түүнчлэн, хэрэглэгчид дээд зэрэглэлийн кофе, шууд аваад идэхэд бэлэн хүнсний бүтээгдэхүүнийг 24 цагийн турш хүссэн цагтаа ороод авах боломжтой болсон нь зөвхөн аялалд гарах хүмүүст биш, тухайн бүс нутагт ажиллаж амьдарч байгаа иргэдэд ч ая тухтай үйлчилгээг үзүүлэх юм.



2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Сэнтрал Коммерс ХХК

Урт хугацааны лоялти хөтөлбөр

Сэнтрал Коммерс ХХК нь Чингис задгай шар айргийн харилцагч нар дээрээ урт хугацааны лоялти хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Харилцагч нартайгаа хамтын ажиллагаагаа сайжруулах, хэрэглэгчид өндөр зэрэглэлийн шар айргийг стандартын дагуу сайн чанартайгаар үйлчлэх тогтмол борлуулалттай харилцагчдыг бэлтгэх зорилготой урт хугацааны хөтөлбөр юм.

Уг хөтөлбөрийн хүрээнд бий болгож буй үнэ цэнэ:

- Шар айргийг стандартын дагуу хэрэглэгчдэд хүргэх
- Хэрэглэгчдээс санал хүсэлт хүлээн аван алдаа дутагдлаа сайжруулах
- Шар айргийн уух соёлыг стандартчилан хэрэглэгчдээ сургах




2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Сэнтрал Коммерс ХХК

Кейтеринг үйлчилгээ

Үйл ажиллагаагаа өргөжүүлэн шинэ борлуулалтын сувагт үйл ажиллагаагаа тэллээ. Энэхүү шинэ үйлчилгээний хүрээнд салбартаа олон жилийн туршлагатай баг ажиллан өндөр зэрэглэлийн стандартаар хэрэглэгчдэдээ үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Үйлчилгээний үнийн хувьд зах зээлд өрсөлдөхүйц хэрэглэгчдэд боломжийн үнийг санал болгож байна.



Standard

Уар айраг хөргөх
төхөөрөмжтэй

Дагалдах хэрэгсэл
бүгд бэлэн


1 ЛИТР 12'000₮

дэлгэрэнгүй:



ЗАХИАЛГА ӨГӨХ ДУГААР
7711-5820

21 ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭХ НЬ ТАНЫ ЗӨҮҮЛ МЭНДЭД ХОРТОЙ



Plus

Уар айраг хөргөх
төхөөрөмжтэй

Дагалдах хэрэгсэл
бүгд бэлэн

Туршлагатай бармен
ажиллана


1 ЛИТР 15'000₮

дэлгэрэнгүй:



ЗАХИАЛГА ӨГӨХ ДУГААР
7711-5820

21 ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭХ НЬ ТАНЫ ЗӨҮҮЛ МЭНДЭД ХОРТОЙ



Premium

Уар айраг хөргөх
төхөөрөмжтэй

Дагалдах хэрэгсэл
бүгд бэлэн

Туршлагатай бармен
ажиллана

Чадварлаг зөөгч танд
үйлчилнэ

1 ЛИТР 18'000₮

дэлгэрэнгүй:



ЗАХИАЛГА ӨГӨХ ДУГААР
7711-5820

21 ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭХ НЬ ТАНЫ ЗӨҮҮЛ МЭНДЭД ХОРТОЙ

2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Чингис Шар Айраг ХХК

Чингис Шар Айраг илүү хүртээмжтэй боллоо

Чингис Шар Айраг ХХК-иас хэрэглэгчдэд хүртээмжтэй байдлаа нэмэгдүүлэх үүднээс 500ml хэмжээтэй шинэ төрлийн савлагааг зах зээлд нэвтрүүллээ. Ингэснээр эцсийн хэрэглэгчид Чингис шар айргийг зөвхөн худалдаалагдаж буй бар, ресторанд үйлчлүүлэх замаар хэрэглэхээс гадна, гэртээ, хөдөө орон нутгаар явах үедээ ч авах боломжтой боллоо.




2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Сэнтрал Кофе Рөүстинг ХХК

“GET” retail кофе бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүлэв

- 2025 оны эхний хагас жилд Central Coffee Roasting компани нь “GET” нэртэй анхны retail бүтээгдэхүүнээ CU Mongolia сүлжээтэй хамтран амжилттайгаар зах зээлд нэвтрүүллээ.
- Уг бүтээгдэхүүн нь өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 430 гаруй CU дэлгүүрт худалдаалагдаж байна.
- Энэхүү нэвтрүүлэлт нь брэндийг олон нийтэд таниулах, хэрэглэгчтэй шууд харьцах сувгийг бий болгох, FMCG сегментэд тэлэх стратегийн эхлэл болж өглөө.



2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Стора Централ ХХК

Технологийн хөгжүүлэлт болон шинэ зах зээлийн холболт:


Хятадын Алибаба группийн Таобао системийн холболтын албан ёсоор өөрийн систем дээр нэвтрүүлэн 2024 онд хэрэгжиж байсан системийн шийдлийг өндөр түвшинд сайжруулав. Ингэснээр Стора-р дамжуулан Таобао-с дээр бараа бүтээгдэхүүн авах үеийн Хайлтын Илэрц, Хурд, Бүтээгдэхүүний мэдээлэл, Барааны чанарын үзүүлэлтүүдийг шууд татан харах шинэчлэлтийг хийлээ.



АНУ-с илүү өргөн сонголттойгоор бүтээгдэхүүн захиалах боломжийг хангах зорилгоор Apple, Patagonia, Alo, Canadian Goose зэрэг брендүүдээр хүрээгээ тэлэн холболт хийж тус брендийн бүтээгдэхүүнийг төгрөгийн төлбөрийн хэрэгслээр болон зээлээр хуваан төлөх боломжоор хэрэглэгчдээ хангав.



Хятадын хамгийн том онлайн худалдааны платформ болох JingDong-той албан ёсны хамтралыг эхлүүлэн Хятадын гигант худалдаа тээврийн компанитай хамтран ажиллаж бүтээгдэхүүн үйлчилгээг нь Монголын зах зээл дээр нэвтрүүлэх анхны Монгол компани болов.



2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

Стора Централ ХХК

Америкаас хамгийн хурдан, Хятадаас тээвэр, үйлчилгээний төлбөр үнэгүй

Тээврийн хугацаа удах асуудал үүсэхийг багасгах, илүү сайжруулан тав тухтай үйлчилгээ хэрэглэгч нартаа бий болгох зорилгоор 1-р улиралд Америк болон Хятадын тээврийн үйл ажиллагаандаа дараах шинэчлэлтийг нэвтрүүлэв.

- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний гол тээврийн урсгал явагддаг Эрээн хотод өөрийн агуулахаа нээн хэрэглэгчдийн ачааг илүү нарийн зохицуулах, ангилан ялгах, эвдрэл гэмтэл үүсэхгүй тээвэрлэх нөхцөлөөр хангах цаашлаад Хятадаас Монгол руу ирэх тээврийн хугацааг бууруулах зорилгоор үйл ажиллагаагаа Эрээн хот руу тэллээ.
- Америкаас ачаа, бараа тээвэрлэх хугацааг илүү богиносгон дунджаар 12-16 хоногт ирдэг байсан хугацааг хэрэглэгч бараа захиалсан хугацаанаас хойш 6-9 хоногт тээвэрлэх боломжийг бий болгов.
- Хятадын тээврийн төлбөрийг үнэгүй болгож хэрэглэгчид илүү ая тухтай, зардлын хувьд том хэмжээнд хэмнэлт гаргаж чадахуйц үйлчилгээг бий болгов.



2025 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд


Стора Централ ХХК

Төлбөрийн илүү олон боломж

- Стора Централ нь Голомт банкны хэрэглээний зээлийг Стора систем дээр нэвтрүүлэхдээ өөрийн үйлчилгээний онцлог тохируулан нэвтрүүлсэн нь хэрэглэгч эхний 14 хоногт хүү төлөхгүй буюу хэрэглэгчийн гар дээр захиалсан бараа тээвэрлэгдэн ирэх хүртэл хүү бодогдохгүй байх нөхцөлөөр хангасан зээлийн үйлчилгээг нэвтрүүлэв.
- Хуваан төлөх үйлчилгээ зөвхөн нэг сонголттой байсныг өргөжүүлэн Pocket Zero-той хамтын ажиллагааг эхлүүлэн урьдчилгаа төлбөргүйгээр гадаадаас хүссэн бүтээгдэхүүнээ захиалан авах боломжоор хангав.

ESG project - StoreForGood

- Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хог хаягдал багасгах, бараа материалын хэрэглээг уртасгах зорилгоор хэрэгжүүлж буй StoreForGood төсөл амжилттай хэрэгжиж Стора-н хэрэглэгчид хоорондоо ном, тоглоом, хувцсаа Сторабокс болон Стора системийн дэд бүтцийг ашиглан солилцон хэрэглэснээр нийт 728 кват цахилгаан, 86,7 тонн ус хэмнэх хэмжээний нөлөөг үзүүлсэн байна.



Нэгтгэсэн орлого, үр дүнгийн товч тайлан

(Сая төгрөгөөр)	2023H1	2023H2	2024H1	2024H2	2025H1
Нийт цэвэр борлуулалт	167,246.8	223,249.8	263,631.9	334,746.8	362,080.0
Борлуулалтын өртөг	161,003.3	206,480.6	217,619.7	270,233.2	293,782.1
Нийт ашиг	6,243.5	16,769.9	46,012.2	64,513.6	68,298.0
Нийт ашгийн хувь	3.7%	7.5%	17.5%	19.3%	18.9%
Үйл ажиллагааны зардал	5,758.3	7,476.3	10,473.5	19,003.2	19,775.6
ХТЭХӨАшиг	485.2	9,292.9	35,538.6	45,510.4	48,522.4
ХТЭХӨАшгийн хувь	0.3%	4.2%	13.5%	13.6%	13.4%
Элэгдэл хорогдол	12,965.1	14,470.9	16,023.9	16,874.4	21,066.6
Мөнгөн бус зүйлс - олз/(гарз)	1,257.6	574.7	1,461.8	701.6	(399.9)
ХТӨАшиг/(алдагдал)	(11,222.4)	(4,603.3)	20,976.5	29,337.5	27,055.8
Санхүүжилтийн зардал	8,165.4	9,341.1	9,746.0	9,692.2	10,282.1
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	(19,387.8)	(13,944.5)	11,230.5	19,645.3	16,773.7
Татварын зардал	(14.8)	(611.1)	578.0	2,372.0	1,055.4
Цэвэр ашиг/(алдагдал)	(19,373.0)	(13,333.3)	10,652.5	17,273.3	15,718.3
Цэвэр ашгийн (алдагдлын) хувь	(11.6%)	(6.0%)	4.0%	5.2%	4.3%

Тайлбар: (1) Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт
(2) Харьцуулалт хийх зорилгоор 2024 оны 2-р хагас жилийн дүн дээр Бизнес нэгдлээс үүссэн нэг удаагийн 19.4 тэрбум төгрөгийн олз цэвэрлэж харуулсан болно

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(Сая төгрөгөөр)	2023.06.30	2023.12.31	2024.06.30	2024.12.31	2025.06.30
Эргэлтийн хөрөнгө	37,503.0	40,170.3	58,096.8	78,429.0	101,717.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,389.8	2,980.6	7,088.5	10,431.5	5,825.8
Дансны авлага	445.5	641.3	3,382.6	6,042.3	11,266.4
Бараа материал	27,855.9	28,250.0	34,354.2	47,194.5	60,397.5
Бусад эргэлтийн хөрөнгө	6,811.8	8,298.4	13,271.5	14,760.7	24,228.2
Эргэлтийн бус хөрөнгө	140,204.1	153,324.6	186,151.1	216,025.8	256,602.3
Биет болон биет бус хөрөнгө	80,532.4	90,193.8	114,667.5	138,430.9	170,375.1
Ашиглах эрхтэй хөрөнгө	49,774.0	50,534.8	51,367.7	60,568.6	69,890.9
Бусад эргэлтийн бус хөрөнгө	9,897.8	12,595.9	20,115.9	17,026.3	16,336.3
НИЙТ ХӨРӨНГӨ	177,707.1	193,494.9	244,247.9	294,454.8	358,320.2
Богино хугацаат өр төлбөр	82,073.1	116,172.9	84,272.1	116,262.5	140,507.7
Дансны өглөг	44,511.8	42,916.4	50,332.3	56,829.4	82,394.1
Богино хугацаат зээл	6,755.9	19,969.9	12,740.8	25,360.3	19,157.5
Бусад богино хугацаат өр төлбөр	30,805.4	53,286.5	21,199.0	34,072.8	38,956.2
Урт хугацаат өр төлбөр	96,569.4	91,590.7	98,607.7	94,880.1	118,782.0
Урт хугацаат зээл	36,583.5	33,999.8	31,072.3	23,868.3	31,058.4
Бусад урт хугацаат өр төлбөр	59,985.9	57,590.9	67,535.4	71,011.9	87,723.6
Эздийн өмч	(935.3)	(14,268.7)	61,368.1	83,312.2	99,030.5
Энгийн хувьцаа	81,776.9	81,776.9	111,425.2	111,425.2	111,425.2
Нэмж төлөгдсөн капитал	13,820.5	13,820.5	45,757.9	45,757.9	45,757.9
Эздийн өмчийн бусад хэсэг	318.7	318.7	318.7	318.7	318.7
Хяналтын бус хувь оролцоо	-	-	3,398.5	8,873.4	9,492.9
Хуримтлагдсан (алдагдал)	(96,851.4)	(110,184.8)	(99,532.2)	(83,063.1)	(67,964.3)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	177,707.1	193,494.9	244,247.9	294,454.8	358,320.2

Тайлбар: (1) Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт
(2) Харьцуулалт хийх зорилгоор 2024 оны 2-р хагас жилийн дүн дээр Бизнес нэгдлээс үүссэн нэг удаагийн 19.4 тэрбум төгрөгийн олз цэвэрлэж харуулсан болно


Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Сая төгрөгөөр)	2023H1	2023H2	2024H1	2024H2	2025H1
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	184,238.0	245,646.3	302,153.8	396,146.9	415,938.3
Мөнгөн зарлагын дүн (-)	(183,158.9)	(245,671.7)	(278,977.5)	(366,962.0)	(365,110.4)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,079.1	(25.4)	23,176.3	29,184.9	50,827.9
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	197.1	297.8	1,445.1	3,984.0	819.4
Мөнгөн зарлагын дүн (-)	(13,387.5)	(19,671.6)	(10,342.3)	(25,992.3)	(43,623.0)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(13,190.4)	(19,373.7)	(8,897.2)	(22,008.3)	(42,803.7)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн (+)	14,800.0	18,837.0	30,891.3	34,847.5	252,738.4
Мөнгөн зарлагын дүн (-)	(17,537.5)	(13,783.2)	(40,990.9)	(38,621.4)	(265,299.5)
Хоорондын тооцоо (+/-)	13,000.0	15,000.0	-	-	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,262.5	20,053.8	(10,099.6)	(3,773.9)	(12,561.1)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн зөрүү	(42.1)	(64.0)	(71.6)	(59.7)	(68.8)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,890.9)	590.8	4,107.9	3,343.0	(4,605.8)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,280.7	2,389.8	2,980.6	7,088.5	10,431.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,389.8	2,980.6	7,088.5	10,431.5	5,825.8


Тайлбар: (1) Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт
(2) Харьцуулалт хийх зорилгоор 2024 оны 2-р хагас жилийн дүн дээр Бизнес нэгдлээс үүссэн нэг удаагийн 19.4 тэрбум төгрөгийн олз цэвэрлэж харуулсан болно

Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд


Борлуулалтын орлого, тэрбум төгрөгөөр




Цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр




Нийт хөрөнгө, тэрбум төгрөгөөр




Үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал, тэрбум төгрөгөөр



Борлуулалтын орлого 2025 H1






Цэвэр ашиг 2025 H1



Тайлбар: (1) Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт
(2) Харьцуулалт хийх зорилгоор 2024 оны 2-р хагас жилийн дүн дээр Бизнес нэгдлээс үүссэн нэг удаагийн 19.4 тэрбум төгрөгийн олз цэвэрлэж харуулсан болно

Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд



Тайлбар: (1) Аудитлагдаагүй санхүүгийн тайлангийн үзүүлэлт
(2) Харьцуулалт хийх зорилгоор 2024 оны 2-р хагас жилийн дүн дээр Бизнес нэгдлээс үүссэн нэг удаагийн 19.4 тэрбум төгрөгийн олз цэвэрлэж харуулсан болно



Анхаарал
хандуулсанд
баярлалаа

Холбоо барих:

И-мэйл: investor@cumongol.mn